- E. Эсэд анаэроб исэлдэлтээр

/162./ Тохиолдлын алдаанд гарахад нөлөөлөхгүй хүчин зүйл аль нь вэ?

- A. Тохируулгын /калибратор/ алдаа
- B. Сорьц боловсруулах явцын алдаа
- C. Температурын хэлбэлзэл
- D. Урвалын хугацааны хэлбэлзэл
- E. Урвалжийн хэмжээний хэлбэлзэл

/163./ Дэлбэнгийн хатгаа нь голдуу дараах үүсгэгчээр үүсгэгддэг:

- A. *Klebsiella pneumoniae*
- B. *Staphylococcus pyogenes*
- C. *Haemophilus influenzae*
- D. *Streptococcus pneumoniae*
- E. *Legionella pneumophila*

/164./ Доорх хамгаалах пептидээс аль нь моноцит эсийн нянгийн эсрэг үйлдлийг дэмждэг вэ?

- A. Кателицидин
- B. Копсин
- C. Протегрин
- D. Индолицидин
- E. Амилаза

/165./ 20 настай, эрэгтэй голтын лимфомын улмаас амьсгалын дистресс орж яаралтай тусламжийн өрөөнд хүргэгдэн ирсэн. Уг өвчтний эмгэг лимфоцитүүдийн гадаргуугийн маркерууд аль эсийн маркертай илүү төстэй байх вэ?

- A. В лимфоцитүүд
- B. Т лимфоцитүүд
- C. Макрофагууд
- D. Сэртэнт ретикулын эсүүд
- E. Лангерхансын эсүүд

/166./ 34 настай эмэгтэй толгой өвдөнө зүрх дэлсэнэ тахикарди хөлрөнө гэсэн зовиуртай. Бодит үзлэгээр цусны даралт хэвийн, гэхдээ толгой өвдөж зүрх дэлсэхээр даралт ихэсдэг Шинжилгээнд баруун бөөрний дээд булчирхайн жижиг хавдар оношлогдсон Шээсэнд юу ихсэх вэ?

- A. Ацетон
- B. Аминолевулины хүчил
- C. Гидрокси-индолацетийн хүчил
- D. Формининыглутамат
- E. Ванлилманделик хүчил

/167./ Өвчтэй хүүхэд оюуны хомсдолтой унаж татдаг, үс арьс нь цайвар цусанд тирозин багасч фенилаланин ихэссэн шээсээр фенилпировиноградын хүчил, фенилэтиламин ихээр ялгарч шээс хөлснөөс нь хөгцөрхүү өвөрмөц үнэр гарч байгаа. Ямар өвчтэй байж болох вэ?

- A. Хромосомын өвчин

- B. Тирозинеми
- C. Фенилкетонури
- D. Алкаптонури
- E. Гомоцистинури

/168./ Чанарын хяналтын сорьцыг гематологийн анализаторын цэс дэх аль горимоор шинжилдэг вэ?

- A. Main menu
- B. Calibration
- C. Maintenance
- D. Quality control
- E. Prime cycle

/169./ Биеийн зах хэсгийн байрлал бүхий үсэрхийлсэн меланомын хамгийн түгээмэл байх байрлалыг заана уу.

- A. Цавь ба гуяны дээд хэсэг
- B. Толгой ба нуруу
- C. Салст бүрхүүл, ялангуяа амны
- D. Алга, ул ба хумсны доод хэсэг
- E. Их бие, мөчдийн дээд хэсэг

/170./ 27 настай эрэгтэй эмнэлэгт хандсан. 2 өдрийн өмнө биеийн байдал сайн байсан боловч бие шарлан, бие ядарч сульдана, хоолонд дургүй болно гэсэн зовиуртай. 6-8 сарын өмнө шивээс хийлгэсэн. Та ямар шинжилгээ хийж оношийг баталгаажуулах вэ?

- A. HBsAg, IgM, HBcAg
- B. Anti-HAV
- C. Anti HCV
- D. Anti HDV
- E. Anti HEV

/171./ Сэрээ булчирхайн гистологи зүслэгт үр хөврөлийн төвд фолликулын идэвхижил аль өвчний үед оношлогдох вэ?

- A. Цочмог үрэвсэл
- B. Архаг үрэвсэл
- C. Сэрээ булчирхайн гиперплази
- D. Сэрээ булчирхайн гипоплази
- E. Тимома

/172./ Тархи нугасны шинжилгээний сорьц авахад дараах зүйлд анхаарах ёстой.

- A. Өвчтөний өвчний түүх, онош
- B. Сорьц авсан цаг
- C. Ариутгасан 3 хуруу шилэнд сорьц авах ба 1 дэх сав- иммунологи биохими, 2 дах сав – бактериологи, 3 дах EDTA хуруу шил-эс ялгах, цитоз тоолох шинжилгээ хийхээр тус тусдараалуулан авах
- D. Цитоз тоолоход шилэн хуруу шилэнд авахгүй
- E. Бүгд зөв

/173./ Мочевин үүсэх явцад биед маш хортой ямар бодис хоргүйждэг вэ?

- A. Креатинин
- B. Аммиак
- C. Индикан
- D. Глутамин
- E. Амин хүчил

/174./ Трепонемын бус (VDRL эсвэл RPR) шинжилгээ хуурамч эерэг гарах нь түгээмэл тохиолддог. Эдгээр өвчний үед аль тохиолдолд хуурамч эерэг гарах боломжтой вэ?

- A. Streptococcus pyogenes
- B. Lupus erythematous
- C. Маляри
- D. Улаан бурхан
- E. Бүгд

/175./ Ямар шалтгаант шүүдэст плевритын үед шингэн цусархаг шинжтэй байх вэ?

- A. Зүрхний шалтгаант

- B. Уушигны үрэвслийн ойролцоох
- C. Хавдрын
- D. Сүрьеэгийн гаралтай
- E. Уремийн шалтгаант

/176./ А 47 настай эрэгтэй халуурах, чичрүүдэс хүрэх, дизурийн зовиуртай. Өвчний түүхээс өмнө нь шээсний замын үрэвслээр өвдөж байгаагүй. Шулуун гэдэсний үзлэгээр түрүү булчирхай маш мэдрэмтгий өвдөлттэй байв. Уг өвчтөнд аль онош нь илүү тохирох вэ?

- A. Цочмог түрүү булчирхайн үрэвсэл
- B. Архаг бактерийн түрүү булчирхайн үрэвсэл
- C. Архаг абактериал түрүү булчирхайн үрэвсэл
- D. Грануломатоз түрүү булчирхайн үрэвсэл
- E. хоргүй түрүү булчирхайн гиперплази

/177./ Цусны хувийн тохироо тодорхойлох шинжилгээний сорьцыг ямар хуруу шилэнд авах вэ?

- A. Цэнхэр тагтай вакумтейнер
- B. Ягаан тагтай вакумтейнер
- C. Шар тагтай вакумтейнер гельтэй
- D. Улаан тагтай вакумтейнер
- E. Ногоон тагтай вакумтейнер

/178./ Шимэгчийн халдвар архагших нь ..... буурсантай холбоотой.

- A. INF-γ
- B. INF-α
- C. INF-β
- D. TNF-α
- E. TNF-β

/179./ Лабораторийн шинжилгээний алдаа ихэнхдээ шинжилгээний аль үед тохиолдох вэ?

- A. Шинжилгээний дараах үе шат
- B. Шинжилгээний өмнөх үе шат
- C. Технологич шижилгээний хариу баталгаажуулах үед
- D. Технологич сорьц боловсруулах үед
- E. Төхөөрөмжөөр сорьц боловсруулах болон шинжлэх үед

/180./ Нийлэг сурфактантыг дараах эмгэгийн үед хэрэглэнэ:

- A. Нярайн цус задрах өвчин
- B. Хиалин мембрант өвчин
- C. Нярайн физиологийн шарлалт
- D. Ретролентал фиброплази
- E. Том судануудын байрлал өөрчлөгдөх

/181./ 28 настай эрэгтэй, их хэмжээний эккимоз тууралт туурч, буйлнаас цус шүүрнэ гэнэ. Бодит үзлэгээр дэлүү болон элэгний томрол илэрсэн. Лабораторын шинжилгээ: захын цусны түрхэцд нормохромын, нормоцитийн цус багадалт, ялтсын тооны цөөрөлт болон цагаан эсийн олшрол илэрсэн. Бүлэгнэлтийн шинжилгээнд протромбин болон зориуд идэвхжүүлсэн тромбопластины хугацаа уртассан, фибрин задралын бүтээгдэхүүн ихэссэн байна. Ясны хэмийн шинжилгээнд Ауэрын биет агуулсан, олон тооны мөхлөг бүхий бласт эсүүд ажиглагдана. Эдгээр бие гүйцээгүй эсүүд ясны хэмийн бөөмтэй эсийн 38%-ийг эзэлж байна. Тохирох оношийг сонгоно уу?

- A. Цочмог эритроид лейкеми
- B. Цочмог лимфойд лейкеми
- C. Цочмог моноцитийн лейкеми
- D. Цочмог миеломоноцитийн лейкеми
- E. Цочмог промиелоцитийн лейкеми

/182./ 2настай эрэгтэй вирусийн болон мөөгийн халдвартай ,таталт өгнө гэсэн зовиуртай Шинжилгээгээр гипокалиемитай,Т эс байхгүйгээс дархлааны эсийн дутагдалтай. Шинж тэмдгээс харахад Di George-н хам шинж оношлогдсон. Т эсийн дутагдал үүсэх нь үр хөврөлийн явцад аль эрхтний хөгжил алдагдсанаас болох вэ?

- A. Залгиурын 3 гч уут
- B. Залгиурын 4 гч уут

- C. Залгиурын 5 гч уут
- D. Ultimobranchial body
- E. Foramen cecum

/183./ Гепатитын С вирусийн нуклейн хүчлийг илрүүлэх тоон үзүүлэлт тодорхойлох шинжилгээнд ямар аргыг сонгох нь хамгийн тохиромжтой вэ?

- A. Гель- электрофорез
- B. Иммунохроматографи
- C. Рестрикцийн эсгэгээр зүсэх
- D. ELISA
- E. RT - PCR

/184./ Хавдрын маркерын зөв тодорхойлолт нь ...

- A. Хавдар үүсч хөгжих үед ялгардаг нэгэн төрлийн уураг
- B. Хавдрын эс үүссэнтэй холбоотойгоор хүний биед нийлэгшдэг бодис
- C. Хавдар үүсэх эсвэл буурч багасахтай холбоотойгоор агуулагдах хэмжээ нь өөрчлөгдөж байдаг аливаа макромолекулууд
- D. Хавдрын үед цусанд илрэх аливаа эсрэгтөрөгчийг хэлнэ.
- E. Хавдрын эсийн гадаргууд илрэх аливаа макро болон микро молекулуудыг хэлнэ.

/185./ 23 настай, эмэгтэйн баруун гуяны дээд хэсэгт хатуувтар тогтоцтой, бор өнгийн, 0.4 см хэмжээтэй элемент гарсан байна. Тууралтаас авсан эдийн шинжилгээнд фибробласт давамгайлсан, гистиоцит, стромал эс ба хялгасан судас зэргээс бүрдсэн дермийн дээд хэсэгт жигд бус байрлах бүтэц харагдсан. Арьсны өнгөн хөрсөнд суурийн эсийн гиперплази ажиглагдсан. Зөв оношийг заана уу.

- A. Дерматофибром
- B. Дерматофибросарком
- C. Фиброксантом
- D. Идээт гранулем
- E. Хатингаршилт гемангиом

/186./ А эмэгтэй өвдөг болон бугуй тохойн үеэр хавдаж, өвдөнө, халуурна гэсэн зовиуртай. Мөчдийн зах хэсэгт тууралт гарч, улайлтат суурин дээр жижиг идээт цэврүү гарсан. Түрхэцийн шинжилгээгээр эс дотрох грам сөрөг кокк илэрсэн. Та ямар үүсгэгчийг сэжиглэж байна вэ?

- A. Gonococcus
- B. Meningococcus
- C. Streptococcus pneumonia
- D. Chlamidia trichomatis
- E. Treponema pallidum

/187./ 35 настай эрэгтэй зүүн гарийн шуу орчим 0.3 см-ийн диаметртэй цайвар хүрэн шархтай. Уг шархлааны зүслэгийг микроскопт харахад арьсны эпидермис болон дерм-эпидермийн заагт уг мэнгэ харагдана. Мэнгэний зэргэлдээ орших эсүүд нэг нөгөөрүүгээ нийлээгүй. Арьсны гадаргуугын буюу гүний эсүүд харагдахгүй хэв шинжгүй эсүүд байхгүй. Энэ шархлааны зөв онош аль нь вэ?

- A. Нийлмэл мэнгэ
- B. Эсийн өөрчлөлттэй мэнгэ
- C. Хүрээтэй мэнгэ
- D. Холбоот мэнгэ
- E. Spitz мэнгэ

/188./ Шээсний сорьцыг хүлээж авахдаа дараах зүйлсийг зайлшгүй анхаарах ёстой

- A. Өвчтөний овог, нэр, нас, хүйс
- B. Сорьц авсан сар, өдөр, цаг
- C. Онош
- D. Сорьц цуглуулсан сав
- E. Бүгд

/189./ Бүдүүн шулуун гэдэсний хавдрын үед ихэсдэг уургийг нэрлэнэ үү.

- A. AFP
- B. CEA
- C. CA19-9



- D. CA125
- E. PSA

/190./ Гөлгөр булчингийн эсийн хэт үржлийн сэдээдэг болон атеросклерозын эмгэг жамтай холбоотой хүчин зүйлийг сонгоно уу.

- A. Тромбоцитын өсөлтийн хүчин зүйл
- B. Өсөлтийн хувиргагч хүчин зүйл  $\beta$
- C. Интерлейкин 1
- D. Интерферон  $\alpha$
- E. TNF

/191./ Лаван (воск) цилиндр ихэвчлэн ..... үед илэрдэг:

- A. Цочмог гломерулонефрит
- B. Цочмог пиелонефрит
- C. Бөөрний чулуу
- D. Цистит
- E. Бөөрний амилоидоз

/192./ 19 настай олигоменорройтой эмэгтэй. Бодит үзлэгээр уг эмэгтэй нь таргалалттай нүүрний үсжилт батгажилт ихэссэн байв. Эмэгтэйчүүдийн үзлэгээр таргалалтаас шалтгаалан умайн дайвар эрхтэн тэмтрэгдээгүйгээс өөрөөр өөрчлөлтгүй. Хэт авиан шинжилгээгээр олон тооны субкортикаль уйланхайнуудтай өндгөвчний 2 талын томрол оношлогдов. Уг өвчтөнд дараахь лабораторын өөрчлөлтөөс аль нь илрэх вэ?

ЛДр (LH) ФСД (FSH) LH/FSH Ratio

- A. буурсан буурсан өндөр
- B. буурсан буурсан бага
- C. буурсан ихэссэн бага
- D. ихэссэн буурсан өндөр
- E. ихэссэн ихэссэн бага

/193./ В бүлгийн цустай хүн ямар эсрэгбие агуулах вэ?

- A.  $\beta$  эсрэгбие
- B.  $\beta$ ,  $\alpha$  эсрэгбие
- C. Анти Д
- D.  $\alpha$  эсрэгбие
- E. Анти С

/194./ Ig E –ийн ийлдсэн дэх агууламж ...

- A. A. 0,1-0,3 мкг/л
- B. B. 0.5-1.9 г/л
- C. C. 1.4-2.4 г/л
- D. D. 100 ng/ ml
- E. E. 20-80 U/L

/195./ Тодорхойгүй хяналтын материал ашиглан ажилтнуудыг үнэлэх чанарын хяналтын шинжилгээ нь аль вэ?

- A. Стандарт ажиллагааны аргачлалын шинжилгээ
- B. Ур чадварын үнэлгээний шинжилгээ
- C. Чанарын дотоод хяналтын шинжилгээ
- D. Стандарчлалын шинжилгээ
- E. Харьцуулалтын шинжилгээ

/196./ c-ras онкогены цэгэн мутаци нь энэ гений бүтээгдэхүүн дараах генттэй холбогдох боломжгүй болгодог:

- A. GAPs
- B. p210
- C. p53
- D. pRb
- E. WT1

/197./ Доорх бүрдлүүдийн аль нь остеокласт идэвхжүүлэгч хүчин зүйл (OAF) нийлэгжүүлж яс хайлалтын голомт үүсгэсэн түгмэл миелом оноштой өвчтний хавдрын сийвэнт эсээс ялгарах вэ?

- A. Интерлейкин 1

- B. Интерлейкин 2
- C. Хавдар үхжлийн фактор B
- D. Ялгаран хөгжих өсөлтийн фактор B
- E. Ялтаст чиглэсэн өсөлтийн фактор

/198./ Сэрээ булчирхайн гистологи зүслэгт үр хөврөлийн төвд фолликулын идэвхижил аль өвчний үед оношлогдох вэ?

- A. Цочмог үрэвсэл
- B. Архаг үрэвсэл
- C. Сэрээ булчирхайн гиперплази
- D. Сэрээ булчирхайн гипоплази
- E. Тимома

/199./ Олон бүтээгдэхүүнт ПГУ-ыг шинжилгээнд тохирохыг сонгоно уу.

- A. Олон хос праймер ашигладаг
- B. Праймер холбогдох температур нь 100оС дээш байдаг
- C. PNH полимераз ашиглан явуулдаг
- D. PNH-ээс цагираг ДНХ үүсгэдэг
- E. Хүний ДНХ полимеразыг ашигладаг

/200./ Өсөлтийн аль үед бактер хамгийн идэвхтэй үржих вэ?

- A. Тайван үе
- B. Эс үхэх хурд удаашрах үе
- C. Логарифм үхлийн үе
- D. Логарифм өсөлтийн үе
- E. Тогтонги үе

/201./ 34 настай, эрэгтэй мөчдийн тэнийлгэгч гадаргуй болон хуйхаар тодорхой зааг хүрээтэй, мөнгөлөг цайвар хайрс бүхий олон тооны тууралттай. Бодит үзлэгээр гарын хурууны хумсны өнгө хувирсан, толио өөрчлөгдсөн байсныг илрүүлсэн. Тохойны тууралтын хайрсыг хуулахад шүүдэр мэт цусан дусал ажиглагдаж байсан (Auspitz шинж эерэг). Гистологийн шинжилгээгээр илрэх шинж аль нь вэ?

- A. Хучуурын доорх цэврүү
- B. Эпидермисийн сэртэн уртсах
- C. Суурийн эсийн гидрофоб дегенерац
- D. Мөхлөг давхаргын олшрол
- E. Дегенерац бүхий холбогч эдийн доорх архаг үрэвсэл

/202./ Энэ өвчний аль хэлбэр вэ?

- A. Тархмал
- B. Цочмог
- C. Архаг
- D. Тээгч болсон
- E. Дахилтат

/203./ 68 настай эмэгтэй нүүрний баруун талд нэг төрлийн дугуй хэлбэр дүрстэй бор өнгөтэй "шигдсэн" шарх гарсан. Энэ шархны эд судлалын шинжилгээгээр аль нь илэрч болох вэ?

- A. Hyperkeratosis with horn and pseudohorn cysts
- B. Hyperkeratosis with papillomatosis but no koilocytosis
- C. Hyperkeratosis with papillomatosis and koilocytosis
- D. A cup-shaped lesion with a central keratin-filled crater
- E. Atypia of epidermal keratinocytes

/204./ Резус бүлэг тодорхойлох шинжилгээний дүн сөрөг гарсан үед ямар арга хэмжээ авах вэ?

- A. Шинжилгээг дахин хийж баталгаажуулна
- B. Хариуг шууд сөрөг гэж бичнэ
- C. Эмчид мэдэгдэнэ
- D. Нэмэлт шинжилгээг өөр оношлуур хэрэглэн эхний шинжилгээгээр гарсан дүнг баталгаажуулна
- E. Батлах шинжилгээг хийн хариуг баталгаажуулсны дараа үйлчлүүлэгчид хариуг өгнө

/205./ Хэрлэг төст үений үрэвсэлтэй хүний үений шингэнээс илэрдэг RF ихэвчлэн ...

- A. IgG-гийн L гинжтэй харилцан үйлчилж байгаа IgM
- B. IgG-ийн H гинжний детерминанттай харилцан үйлчилж байгаа IgM
- C. Нянгийн антигентэй харилцан үйлчилж байгаа IgE
- D. Коллагены эсрэг эсрэгбие
- E. ДНХ-гийн эсрэг эсрэгбие

/206./ 41 настай эмэгтэй, толгой давтамжтайгаар, хүчтэй өвдөнө, харааны асуудал улам нэмэгдэнэ гэсэн зовиуртай. Бодит үзлэгээр АД 220/150 (мм.м.у.б.). Эмэгтэйн эмнэлзүйн шинж тэмдэгтэй холбоотой эмгэгийг нэрлэнэ үү.

- A. Шохойжилтот склероз
- B. Бөглөрөлтөт атериосклероз
- C. Гиперпластик атериосклероз
- D. Гиалины аттериосклероз
- E. Бөглөрөлтөт тромбангиит

/207./ Ямар эмгэгийн үед Бенс-Джонсын уураг илрэх вэ?

- A. Бөөрний амилоидоз
- B. Архаг гломерулонефрит
- C. Миеломын өвчин
- D. Бөөрний сүрьеэ
- E. Цочмог гломерулонефрит

/208./ 32 настай эмэгтэй аменорройн дараахь олигоменоррой илэрсэн, дараа нь бэлгийн 2догч шинж алдагдсан зовиуртай. Мөн түүнд батгашил, хоолой бүдүүрэх, чамархайн үс халцрах зэрэг зовиур илэрсэн. Уг шинж тэмдэг дараахь өндгөвчний хавдаруудаас аль хавдарын үед илэрдэг вэ?

- A. Хучуур эсийн хавдар
- B. Строммын хавдар
- C. Үр хөврөлийн эсийн хавдар
- D. Гадаргуугын хавдар
- E. Метастаз

/209./ Цусны АВО бүлэг тодорхойлох Anti - A оношлуур ямар эсрэгбиеийг агуулдагийг бичнэ үү.

- A.  $\beta$ ,  $\alpha$  эсрэгбие
- B.  $\beta$  эсрэгбие
- C. с эсрэгбие
- D.  $\alpha$  эсрэгбие
- E. d эсрэгбие

/210./ Enterbacteriaceae-н бүлийн нянг эмчлэх сонголтын эмүүдийг заана уу.

A. Аминогликозид, триметоприм сульфаметоксазол, цефалоспорины гуравдугаар уламжлал

- B. Ампициллин, наликсиин хүчил
- C. Стрептомицин, изониазид
- D. Хлорамфеникол, ампициллин, колистин
- E. Ciprofloxin Gentamecini

/211./ Бодит хугацааны ПГУ шинжилгээний аргыг ямар тохиолдолд хэрэглэхгүй вэ?

- A. HCV, HBV-ийн ачаалал тодорхойлох шинжилгээ
- B. HCV, HBV-ийн генотип тодорхойлох шинжилгээ
- C. HBeAg тоон үзүүлэлтээр тодорхойлох
- D. HCV, HBV-ийн эмчилгээний үр дүнг хянах
- E. HDV-ийн хавсарсан халдварыг илрүүлэх

/212./ Анкилозын спондилит болон дараах бүрдэлийн хооронд хүчтэй хамааралтай байдаг:

- A. HLA- B27
- B. HLA- DR3
- C. HLA- DR4
- D. HLA- A3
- E. HLA- BW47

/213./ Эдгээрийн аль нь ерөнхий хаван, гипоальбуминеми, гиперхолестролеми, илэрхий протейнури, өөхөн цилиндр болон өөхөн биет шээсэн илрэх шинж тэмдгийн шалтгаан болох вэ?

- A. Нефритик синдром
- B. Нефротик синдром
- C. Бөөрний хурц дутагдал
- D. Бөөрний сувганцрын гажиг
- E. Бөөр шээсний замын халдвар

/214./ 35 настай эрэгтэй зүүн гарийн шуу орчим 0.3 см-ийн диаметртэй цайвар хүрэн шархтай. Уг шархлааны зүслэгийг микроскопт харахад арьсны эпидермис болон дерм-эпидермийн заагт уг мэнгэ харагдана. Мэнгэний зэргэлдээ орших эсүүд нэг нөгөөрүүгээ нийлээгүй. Арьсны гадаргуугын буюу гүний эсүүд харагдахгүй хэв шинжгүй эсүүд байхгүй. Энэ шархлааны зөв онош аль нь вэ?

- A. Нийлмэл мэнгэ
- B. Эсийн өөрчлөлттэй мэнгэ
- C. Хүрээтэй мэнгэ
- D. Холбоот мэнгэ
- E. Spitz мэнгэ

/215./ Праймер ямар үүрэгтэй вэ?

- A. ДНХ-ийн өвөрмөц дарааллыг зүсэх
- B. ДНХ-ийн өвөрмөц дарааллыг таньж ДНХ-ийн нийлэгжлийг идэвхижүүлэх
- C. ПГУ-ыг зогсоох
- D. ДНХ-ийн утаслагтай өвөрмөц бусаар холбогдож олон дахин хуулбарлах
- E. ПГУ-ын үед устөрөгчийн холбоог салгах

/216./ Колони гэж юу вэ?

- A. Хэд хэдэн зүйл микробын бөөгнөрөл
- B. Нэг зүйл бичилбиетний бөөгнөрөл
- C. Нэг эсийн бөөгнөрөл
- D. Нэг эсээс ургасан нэг зүйлийн микробын бөөгнөрөл
- E. Микробын бөөгнөрлөөс үүссэн популяц

/217./ 52 настай, эрэгтэйн их биеээр олон тооны чинэрсэн цэврүү гарсан ба харин амны салст гэмтээгүй. Бодит үзлэгээр хагарсан цэврүү байхгүй байсны зэрэгцээ Nikolsky –ийн шинж сөрөг байлаа. Цэврүүнээс авсан гистологийн шинжилгээгээр эпидермисийн доор байрлах хөндий илэрсэн. Өвөрмөц будгийн аргаар IgA илрээгүй. Дараах эмгэгт тохирох оношийг заана уу.

- A. Энгийн цэврүүтэл
- B. Пемфигоид
- C. Херпес хэлбэрийн дерматит
- D. Хайрст үлд
- E. Хавтгай үлд

/218./ Ямар шинжилгээ хийх вэ?

- A. Тэжээлт орчинд өсгөвөрлөх
- B. Фермент холбоот эсрэг биеийн урвал
- C. Наалдуулах урвал
- D. RPR, TRHA
- E. Strep test

/219./ 23 настай эмэгтэй хүзүүгийнхээ зүүн талын арьсан доор 0.4 см-ийн зангилаатай. Өөхөн ургацагыг эмнэлзүйч эмч лабораторийн эмгэг судлаачид шилжүүлсэн. Гистологийн зүслэгээр уйланхайн арьсны бүтэц давхраат хавтгай эс, давхар мөхлөгт эсээр бүрхэгдсэн, эс хоорондын зай кератинаар дүүргэгдсэн. Энэ уйланхай цооролгүй, уйланхайд өөр ямар нэг хэвийн бус бүтэц илрээгүй байна. Онош юу вэ?

- A. Acrochordon
- B. Уйланхайн хавдар
- C. Хучуурын дотор орших уйланхай
- D. Арьсан доорх мэнгэ
- E. Уйланхай

/220./ Грам эерэг бактерийн эсийн ханын бүтцийг нэрлэнэ үү?

1. Пептидогликаны нэг үе
2. Пептидогликаны олон үе
3. Пептид
4. Тейхийн хүчил
5. Тосны хүчил

/221./ Скаттерграм бүхий шинжилгээний хариунаас ямар онцлог зүйл харж болох вэ?

1. Эсүүдийн тоон дүн
2. Эсүүдийн харьцаа
3. Эсүүдийн тоон дүн, дүрслэлийн уялдаа
4. Шинжилгээний дүнгийн хазайлт
5. Шинжилгээний дүгнэлт

/222./ Сепсистэй хүмүүсийн нас барах эрсдэлтэй шууд хамааралтай хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. TNF
2. IL-1
3. IL-6
4. Липополисахаридын түвшин
5. Цусны бүлэг

/223./ Өвчтөний лабораторийн шинжилгээний үр дүнг тайлбарлах үүрэгтэй мэргэжилтэнг сонгоно уу?

1. Эмнэлгийн захирал
2. Эмнэлзүйн эмгэг судлаач эмч
3. Эрүүл мэндийн туслах ажилтан
4. Эмчлэгч эмч
5. Лабораторийн техникч

/224./ Хүнд эмгэг үүсгэдэг эгэлбиетнийг нэрлэ

1. *Entamoeba histolytica*
2. *Trichomonas vaginalis*
3. *Balantidium coli*
4. *Leishmania donovani*
5. *Plasmodium malariae*

/225./ Бактерийн өсөлтийн үе шатуудыг нэрлэ

1. Тайван үе
2. Саатах
3. Логарифм өсөлтийн үе
4. Үржлийн хурд удаашрах үе
5. Нас гүйцэх үе

/226./ Аль халдварын үед өвчин цочмог илэрдэг вэ?

1. HCV
2. HAV
3. HDV
4. HBV
5. HCV ба HDV

/227./ Резус бүлэг тодорхойлох шинжилгээний урвалын дүн ямар үед шууд хариуг үйлчлүүлэгчид өгөх вэ?

1. Анти Д урвалжаар шинжилхэд 1+ хариу өгсөн
2. Анти Д урвалжаар шинжилхэд 3+,4+ хариу өгсөн
3. Дотоод хяналтын дүн буруу гарсан
4. Дотоод хяналт зөв явагдсан
5. Анти Д урвалжаар шинжилхэд ±хариу өгсөн

/228./ Хувийн тохироо тодорхойлох шинжилгээний дотоод хяналтыг хэрхэн хийх вэ?

1. Лаборатори дотоодоо бэлтгэсэн хяналтын материалаар хийнэ
2. Үйлдвэрлэгчийн бэлтгэсэн хяналтын материалыг ашиглана
3. Өвчтөний сорьцыг өөрийнх нь ийлдэстэй шинжилж хяналт болгоно
4. Хувийн тохироо тодорхойлох шинжилгээнд дотоод хяналт хийгдэхгүй

5. Сэлбэх бүтээгдэхүүний ийлдсийг улаан эстэй ашиглана  
/229./ Доорхи аргуудын аль нь чанарын гадаад үнэлгээний арга вэ?

1. Ур чадварын үнэлгээний арга
2. Хөндлөнгийн байгууллагаар ажлын байранд үнэлгээ хийлгэх арга
3. Тоон үзүүлэлтийн чанарын хяналтын арга
4. Лабораториуд хоорондоо сорьцоо солилцон шинжлэх арга
5. Чанарын дотоод хяналтын материалыг шинжлэх арга

/230./ Цус бүлэгнэлтийн шинжилгээний үндсэн үзүүлэлт аль нь вэ?

1. PT
2. APTT
3. TT
4. Fbn
5. D-dimer

/231./ Ямар үед цусны хувийн тохироо тохирсон гэж үзэх вэ?

1. Өвчтөний ийлдэс, сэлбэх улаан эсийн хөвмөлтэй тасалгааны хэмд наалдац өгөөгүй
2. Өвчтөний ийлдэс, сэлбэх улаан эсийн хөвмөлтэй +37 хэмд наалдац өгөөгүй
3. Өвчтөний ийлдэс, сэлбэх улаан эсийн хөвмөлтэй кумбсын шатанд наалдац өгөөгүй
4. Өвчтөний ийлдэс сэлбэх улаан эсийн хөвмөлтэй тасалгааны хэмд 1+ наалдац өгсөн
5. Өвчтөний ийлдэс сэлбэх улаан эсийн хөвмөлтэй кумбсын шатанд 1+ наалдац өгсөн

/232./ Гематологийн анализаторын скаттерграм бүхий шинжилгээний хариунаас ямар онцлог зүйл харж болох вэ?

1. Эсүүдийн тоон дүн
2. Эсүүдийн харьцаа
3. Эсүүдийн тоон дүн, дүрслэлийн уялдаа
4. Шинжилгээний дүнгийн хазайлт
5. Шинжилгээний дүгнэлт

/233./ Аутоиммун эмгэг нь ...

1. Эс хордуулагч Т эс хэт идэвхжсэнээс
2. Дархлааны тэвчил тасарснаас
3. В эсийн идэвхи дарангуйлагдсанаас
4. Дархлааны зохицуулах механизм алдагдсанаас
5. Хавсаргын дутмагшлаас болж үүснэ.

/234./ Дараах хариултын аль нь зөв бэ?

1. Өвчтөний мэдээллийн нууцыг хадгалах нь чанарын удирдлагын хөтлөл зүйн зорилго мөн.
2. Лабораторийн мэдээлэл зүйг хөтлөн явуулахад заавал компьютерийн систем систем ашиглах ёстой.
3. Цаасан систем ашиглан өвчтөний мэдээлэлзүйг хөтлөн явуулах нь компьютерийн систем ашиглахаас давуу талтай
4. Компьютерийн систем ашиглан өвчтөний мэдээллийг хөтлөн явуулахад үргэлж хуулбар хувь хийх шаардлагатай
5. Сорьцын чанар муу байсан тухай тусгай мэдээллийг шинжилгээний хариунд оруулна.

/235./ Электрофорезийн явцад сиивэнгийн уураг дараах байдлаар салдаг

1. Альбумин
2.  $\alpha$  глобин
3.  $\gamma$  глобин
4.  $\beta$  глобин
5. амилаза

/236./ Лабораторит чанарын систем нэвтрүүлэх ажлыг төлөвлөхдөө:

1. Төлөвлөгөөний бүх үе шатыг богино хугацаанд хэрэгжүүлэх бэлтгэлийг хангасан байна.
2. Больницын захиргаатай зөвшилцөнө
3. Хэрэгжилтийг хянах компьютерийн систем ашиглана.
4. Төлөвлөгөөнд чанарын стандартын бүх арван нэгэн элементийг оруулна \*
5. Анхны төлөвлөгөөгөө боловсруулсны дараа лабораторийн бүх ажилтанд мэдээлнэ

/237./ Аутоэсрэгбиеүүдийг нэрлэнэ үү.

1. ANA
2. AMA
3. RF
4. CRP
5. AFP

/238./ Гематологийн шинжилгээний хариу ямар байвал цусны түрхэцийг шинжлэх шаардлага тавих вэ?

1. Blasts? дүгнэлт гарсан үед
2. Variant lymphs? дүгнэлт гарсан үед
3. Imm grans/bands? дүгнэлт гарсан үед
4. Abnormal RBC? дүгнэлт гарсан үед
5. Abnormal PLT? дүгнэлт гарсан үед

/239./ Нефротик хамшинжийн үеийн эмнэлзүй болон лабораторийн өвөрмөц шинж:

1. Оксалатури
2. Цонхигор арьс
3. Гипопротеинеми
4. Их хэмжээний протеинури
5. Диспротеинеми

/240./ Цусны АВО бүлэг тодорхойлоход ямар эсрэгтөрөгч, эсрэгбиетэй уулзахад наалдац буюу агглютинаци үүсэх вэ?

1. А эсрэгтөрөгч β эсрэгбиетэй,
2. А эсрэгтөрөгч α эсрэгбиетэй,\*
3. α эсрэгбие, β эсрэгбиетэй,
4. В эсрэгтөрөгч β эсрэгбиетэй,\*
5. А эсрэгтөрөгч β эсрэгбиетэй тус тус уулзахад наалдац үүснэ

/241./ Чанарын удирдлагын тогтолцоо (QMS) ямар үйл ажиллагаанд чухал вэ?

1. Үйл ажиллагаа нь жигд байдлыг хангах
2. Лабораторын удирдлагын үйл явц бүрийг үе шат нэг бүрээр тогтоож удирдлагын хариуцлагын ачааг хөнгөлөх
3. Зохицуулалтын шаардлагыг хангах
4. Шинжилгээний өртөг тогтоох
5. Лабораторийн байршилыг тогтоох

/242./ Хувийн тохироо тодорхойлох шинжилгээний сорьц ямар шаардлага хангасан бол хүлээн авч шинжлэх вэ?

1. Улаан эсийн бүтээгдэхүүн сэлбэх өвчтөнөөс улаан тагтай вакумтейнерт авсан
2. Хуруу шил болон шинжилгээнд илгээх бичиг дээрх мэдээллүүд тохирч байгаа
3. Цус задрал илрээгүй
4. Сийвэн сэлбэх өвчтөнөөс улаан тагтай вакумтейнерт авсан
5. Бага зэргийн цус задралын шинж илэрсэн

/243./ Улаан эсийн тунах хурд тодорхойлоход нөлөөлөх алдаа бол?

1. Цитрат натри, цусны харьцаа алдагдах
2. Цус бүлэгнэсэн байх
3. Панченковын гуурсан соруулыг тавиурт хазгай байрлуулах
4. Температурын шаардлага хангагдаагүй
5. Цусыг улаан бөглөөтэй хуруун шилэнд авах

/244./ Шимэгч хорхойн эсрэг голчлон ..... үүснэ.

1. IgG2
2. IgG4
3. Ig1
4. IgE
5. IgM

/245./ Цусны түрхцэнд эсүүдийг ялгаж таних шалгуур бол

1. Эсийн хэмжээ
2. Бөөм, цитоплазмын харьцаа
3. Хроматин бүтэц
4. Бөөмийн доторх бөөмхөн

5. Цитоплазмын мөхлөг

/246./ Гемоглобинури доорх аль эмгэгийн үед тохиолдох вэ

1. Цус задралын үед
2. Бөөрний хурц дутагдал
3. Хурц нефрит
4. Сахартай шижин
5. Сахаргүй шижин

/247./ Тэжээлт орчныг зориулалтаар нь хэрхэн ангилах вэ?

1. Энгийн
2. Тусгай
3. Ялгаварлан оношлох
4. Нийлмэл
5. Хагас шингэн

/248./ Элэгний цирроз өвчний үед ийлдсэнд уургийн ямар фракцын агууламж ихэсдэг вэ?

/C/

1. Альбумин
2.  $\beta$  глобулин
3.  $\alpha_1$  глобулин
4.  $\gamma$  глобулин
5.  $\alpha_2$  глобулин

/249./ C урвалж уураг нь

1. IgM-тэй төсөөтэй  $\beta$  глобулины пентамер бүтэцтэй
2. Үрэвсэлийн хурц үед нийлэгшдэг
3. Элгэнд нийлэгжинэ
4. Хавсаргын уураг
5. Опсониний үүрэгтэй

/250./ Улаан эсийн тооцооллын үзүүлэлтийг нэрлэнэ үү?

1. MCV
2. MCH
3. MCHC
4. MPV
5. HCT

/251./ Чанарын шинжилгээ гэж юу вэ?

1. Алдаа гарах магадлал багатай арга
2. Тоон үзүүлэлт гардаггүй шинжилгээ
3. Хэвийн хэмжээг тогтооход хэрэглэдэг статистик арга
4. Өвчний оношийг тодруулахад хэрэглэдэг гол арга
5. Зөвхөн номонд л байдаг

/252./ Скаттерграм дээр эсүүдийг бүлэглэн дүрслэх үндэс нь дараах онцлог шинжтэй холбоотой.

1. Эсийн хэмжээ
2. Эсийн бөөм, мөхлөгийн байдал
3. Эсийн ДНХ, РНХ агууламж
4. Эсийн хэлбэр
5. Эсийн тоо

/253./ Аутоиммун урвалж чанар дараах үндсэн шинжтэй. Үүнд:

1. Аутоиммун урвал үүсэхэд дархлаа зохицуулга алдагдах, удамшил, эдийн гэмтэл, халдвар зэрэг хоорондоо уялдаатай олон хүчин зүйл нөлөөлдөг

2. Аутоиммун өвчин эрхтэн өвөрмөц болон тогтолцооны түгээмэл шинжтэй байдаг

3. Эдийн гэмтэл нь дархлааны өөр өөр эффектор механизмын үйлчлэлээр үүснэ

4. Эрүүл хүмүүст, цөөн тооны барьцаал чанар багатай IgM бүтэцтэй ауто-эсрэгбие үүсч болох боловч эдийн гэмтлийг үүсгэдэггүй

5. Эдийн гэмтэл нь дархлааны нэг ижил эффектор механизмын үйлчлэлээр үүснэ

/254./ Скаттерграм дээр эсүүдийг бүлэглэн дүрслэх үндэс нь дараах онцлог шинжтэй холбоотой

1. Эсийн хэмжээ



2. Эсийн бөөм, мөхлөгийн байдал
3. Эсийн ДНХ, РНХ агууламж
4. Эсийн хэлбэр
5. Эсийн тоо

/255./ Цусны АВО бүлгийг шууд аргаар тодорхойлоход бэлтгэх зүйлсийг нэрлэнэ үү.

1. Бүлэг тодорхойлох улаан эсийн хөвмөл
2. Эсрэгбие агуулсан ийлдсүүд
3. хуруу шил
4. Центрифуг
5. шинжилгээний протокол

/256./ Дараах тодорхойлолт, үүрэг ажлын аль нь калибраторт хамаарах вэ?

1. Оношлуурын чанарыг шалгах зориулалттай
2. Сорьцын чанарыг шалгах зориулалттай
3. Багажийн эвдрэлээс урьдчилан сэргийлэх зориулалттай
4. Тодорхой концентрацийн шинжлэгдэхүүн агуулах зориулалттай
5. Ажилтны чадварыг шалгах зориулалттай

/257./ Иммуно-серологийн шинжилгээнд эерэг, сул эерэг болон сөрөг хяналт тавих дараах шаардлагуудын аль нь зөв бэ?

1. Эерэг дүн зөв гэдгийг баталгаажуулах
2. Сул эерэг дүнг тодорхойлох боломжийг хангах
3. Оношлуурын хугацаа дуусаагүй гэдгийг баталгаажуулах
4. Сөрөг дүн зөв гэдгийг баталгаажуулах
5. Бохирдолыг илтгэх

/258./ Чанарын гадаад үнэлгээ бол чанарын удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн мөн. Учир нь

1. Өдөр тутам өвчтөний шинжилгээний хариуны үнэн зөвийн баталгаа болж өгдөг
2. Лабораторийн шинжилгээний өмнөх үе, шинжилгээний үе, шинжилгээний дараах үеийн үйл ажиллагааг байнга хянаж байдаг
3. Чанарын гадаад хяналтын сорьцын аль нэг шинжилгээний чанарын тухай мэдээллийг хэрэглэгчид өгөх боломж олгоно
4. Лабораторийн шинжилгээний чанарыг хэмжих бодитой боломж олгоно
5. Лабораториудын хооронд мэдээлэл солилцох тогтолцоог сайжруулдаг

/259./ Уушигны эдийн задралын үед цэрэнд дараах талстууд илэрнэ:

1. Гематоидин
2. Холестерин
3. Өөхний хүчил
4. Саармаг өөх тос
5. Шарко-Лейден

/260./ Резус бүлэг тодорхойлох шинжилгээний хариу 1+ гарсан үед ямар арга хэмжээ авах вэ?

1. Резус бүлэг эерэг гэсэн хариуг шууд өгнө
2. Резус бүлэг тодорхойлох шинжилгээний хариу тодорхойгүй гэж үзнэ
3. Резус бүлэг тодорхойлох шинжилгээг дахин давтаж хийнэ
4. Наалдах урвалын хүч сул байгаа тул өөр оношлуур ашиглан давтан шинжилж байж хариуг өгнө
5. Резус бүлэг сөрөг гэсэн хариуг шууд өгнө

/261./ Стандарт ажиллагааны аргачлалыг (САА) албан ёсоор баталсан байх нь яагаад чухал вэ?

1. САА нь лабораторийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлдэг
2. САА нь лабораторийн шинжилгээг стандартчилдаг
3. САА нь лабораторийн ажилтнуудын дагаж мөрдөх баримт
4. САА нь шинжилгээний аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай
5. САА нь шинжилгээний үнийг тогтоодог бичиг баримт

/262./ Хувийн тохироо тодорхойлох шинжилгээний сорьц ямар шаардлага хангасан байх вэ?

1. Цус үл бүлэгнүүлэгч бодис агуулаагүй хуруу шил дээр авсан өвчтөний сорьц

2. Хуруу шил дээрх тэмдэглэл, шинжилгээнд илгээх бичиг дээрх мэдээлэл тохирч байгаа

3. Хүрэлцээтэй хэмжээтэй, цус задрал болоогүй

4. Өвөрмөц шаардлага тавигдахгүй

5. Цус сэлбүүлэх өвчтөнийзөвхөн ийлдэс

/263./ Стеркобилин баасанд байхгүй байх нь..... эмгэгийн үед тохиолдоно:

1. Бүдүүн гэдэсний шархлаа

2. Нойр булчирхайн үйл ажиллагааны дутмагшил

3. Эзофагит

4. Цөсний цоргоны бөглөрөл

5. Гастрит

/264./ Бүрээс ямар үүрэгтэй вэ? Ямар аргаар илрүүлэх вэ?

1. Ожешкийн арга

2. Гинс-Буррийн арга

3. Тэжээлийн бодис зөөвөрлөх

4. Залгиур эс, эсрэгбиеэс хамгаалах

5. Удмын материал дамжуулах

/265./ Ямар өвчний үед ерөнхий усгүйжилт бий болох вэ?

1. Түлэгдэлт

2. Түгжрэл

3. Полиури

4. Ходоодны хавдар

5. Холер

/266./ Экссудатын трансудатаас ялгарах онцлог юу вэ

1. Уураг ихтэй

2. Хувийн жин өндөр

3. Ривальтын сорил эерэг

4. Хувийн жин бага

5. Ривальтын сорил сөрөг

/267./ Цусны АВО бүлгийг урвуу аргаар тодорхойлох шинжилгээ хийхэд шаардагдах зүйлсийг нэрлэнэ үү

1. Бүлэг тодорхойлох ийлдэс

2. А болон В бүлгийн стандарт улаан эс

3. Хуруу шил 10x 75мм, 12 x 75мм

4. Хуруу шилний центрифуг

5. Нэг удаа хэрэглэх дусаагуурууд

/268./ Риккетсигээр үүсгэдэг өвчнүүдийг нэрлэ.

1. Эсэргэнэт балнад

2. Ку-чичрэг

3. Дахидаг балнад

4. Иж балнад

5. Гэдэсний балнад

/269./ Гистограммын бүрдэл дүрслэгдэх үндэс нь

1. Эсийн хэлбэр

2. Эсийн тоо

3. Эсийн бөөм

4. Эсийн эзэлхүүний хэмжээ

5. Эсийн мөхлөг

/270./ Дараах үүрэг ажлын аль нь дотоодын аудитэд хамаарах вэ?

1. Гаднын аудиторт сар бүр мэдээлэл өгөх

2. Шаардлагатай сургалтын чиглэлийг тогтоох мэдээлэл олж авах

3. ISO-ийн магадлан итгэмжлэлийг авахаар зорьж буй лабораторид шаардлагагүй

4. Чанарын менежментийн тогтолоцооны үйл ажиллагаа зөв явагдаж буйг баталгаажуулах

5. Хөндлөнгийн байгууллага, этгээд, гаднын хүнээр хийлгэнэ

/271./ Хөндлөнгийн хяналт явуулахад аудиторын баримтлах гол зарчим юу вэ?

1. Лабораторийн үйл ажиллагааг тогтоосон стандарттай харьцуулах
2. Лабораторийн нийт үйл ажиллагааг шалган үнэлэх
3. Эрүүл мэндийн газарт тайлагнах хүртэл үнэлгээний үр дүнг нууцлах
4. Гол нь ур чадварын үнэлгээ явуулах
5. Зөвхөн шинжилгээ хийх үе шаттай холбоотой үйл явцыг үнэлэх

/272./ Хавдрын маркерын хэрэглээ

1. Анхдагч онош болон хавдрын байршил, үе шатыг тодорхойлох
2. Эмчилгээний чанарыг хянах зорилгоор
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт
4. Өвчтөний тавиланг тогтоох зорилгоор
5. Хавдрын хэмжээг тодорхойлох

/273./ Лабораторийн бус ажилтнуудад сорьц авах ажилбарыг ойлгуулж мэдээлэх хамгийн оновчтой арга нь аль вэ?

1. Тасгуудыг лабораторийн чанарын гарын авлагаар хангах
2. Сорьц авдаг бүх хэсгүүдийг Лабораторийн Гарын авлагаар хангах
3. Ахлах сувилагч нарыг сургалтанд хамруулж, тэднээр сорьц авах үйл явцыг хянуулах
4. Сорьц авдаг хүн бүрийг ганцаарчилсан сургалтанд хамруулах
5. Байгууллагын даргад уг ажлыг хариуцуулах

/274./ Аргачлал нь

1. “Юу хийх вэ?” гэдгийг зааж өгдөг ба байгууллагын ерөнхий зорилго, чиглэлийг тодорхойлж өгдөг.
2. “Хэзээ хийх вэ?” гэдгийг зааж өгдөг ба цагийн хуваарийг тодорхойлж өгдөг
3. “Яагаад ийм болов?” гэдгийг зааж өгдөг ба түүнийг өдөр тутмын тэмдэглэл дээр хөтөлдөг тул уг үйл явдал хэдийд тохиолдсоныг заадаг
4. “Яаж хийх вэ?” гэдгийг зааж өгдөг ба лабораторийн ажилтан алдаагүй үнэн зөв хариу гаргаж авахын тулд ягштал мөрдөх шаардлагатай ажилбарыг шат болгоноор нь дэс дараатай харуулдаг
5. “Хэн хийх вэ?” гэдгийг зааж өгдөг ба ажлын байрны зорилго, чиглэлийг тодорхойлж өгдөг

/275./ Өвчтөний мэдээлэл зүйг хөтлөн явуулахад компьютерийн систем ашиглах нь цаасан дээр тэмдэглэж хөтлөн явуулахаас давуу талтай. Учир нь:

1. Илүү алдаагүй байдаг
2. Цаг мөнгө хэмнэнэ
3. Өвчтөний тухай мэдээлэл бага шаардана
4. Мэдээллийг сэргээхэд хялбар
5. Ажилтнаас чадвар бага шаардана

/276./ СА-125 маркер ... ихэсч болно

1. Умайн хүзүүний өмөнгийн үед
2. Хөхний өмөнгийн үед
3. Уушгины гаралтай өмөнгийн үед
4. Өндгөвчний өмөнгийн үед
5. Бага тазны хөндийн өмөнгийн үед үед

/277./ Хурц үрэвслийн уургуудыг заана уу?

1. С реактив уураг
2. Альфа 1 антитрипсин
3. Альфа 2 макроглобулин
4. Фибриноген
5. Церулоплазмин

/278./ Цусны АВО бүлгийг хавсарсан аргаар үзнэ гэж юу вэ?

1. Анти Д урвалж ашиглан Д эсрэгтөрөгчийг тодорхойлох
2. Моноклон Анти А, Анти В оношлуур буюу О, А, В бүлгийн стандарт ийлдэс ашиглан улаан эсийн гадаргуу дээр байгаа эсрэгтөрөгчийг тодорхойлох
3. Эмнэлзүйн хувьд ач холбогдолтой эсрэгбиеүүдийг тодорхойлох
4. А, В бүлгийн угаасан улаан эс ашиглан ийлдсэнд агуулагдах эсрэгбиеийг ашиглах
5. Улаан эсийн гадаргуу дээрхи келл эсрэгтөрөгчдийг тодорхойлох

/279./ Ямар эмгэгийн үед Шарко-Лейдений талст илрэх вэ?

1. Уушигны буглаа
2. Бронхоэктаз
3. Уушигны үрэвсэл
4. Гуурсан хоолойн багтраа
5. Уушигны сүрьеэ

/280./ Үр ямар үүрэгтэй вэ? Түүнийг ямар аргаар илрүүлэх вэ

1. Үржлийн эрхтэн
2. Ожешкийн аргаар
3. Нейссерийн аргаар
4. Орчны тохиромжгүй нөхцлөөс хамгаалах
5. грамын аргаар

/281./ Цусны бүлгийг хуруу шилний аргаар тодорхойлох үед шинжлэх улаан эсийн хөвмөлийг ямар концентрациар бэлтгэх вэ?

1. Улаан эсийн 2%-ийн хөвмөл
2. Улаан эсийн 3% хөвмөл
3. Улаан эсийн 5% хөвмөл
4. Улаан эсийн 0.8% хөвмөл
5. Улаан эсийн 50% хөвмөл

/282./ Мөөгийн онцлог шинжийг нэрлэнэ үү?

1. Эсийн бүтцээрээ эукариотад хамаарна
2. Спороор үржинэ
3. Тэжээлт орчинд өсгөвөрлөгдөнө
4. Эсийн бүтцээрээ прокариотод хамаарна
5. Хөндлөн хуваагдаж үржинэ

/283./ Аутоиммун өвчний ангилал.

1. Удмын урьдал нөхцөлтэй буюу нөхцөлгүй анхдагч аутоиммун өвчнүүд
2. Хоёрдогч аутоиммун өвчин
3. Хавсрагын удмын гажиг бүхий өвчнүүд
4. Вирусын ужиг халдвар
5. Дээрх эмгэгүүд хавсрах

/284./ Гемолиз үүсэх шалтгаан:

1. Жижиг, нарийн зүүгээр цус авах
2. Хуруу шилийг сэгсрэх
3. Спирт хатаагүй үед хатгалт хийх
4. Хоол идсэний дараа сорьцыг авах
5. Идэвхитэй дасгал хөдөлгөөн

/285./ Цусны түрхцийг тусгайлан будаж юуг илрүүлэх вэ?

1. Жоллийн биет
2. Сидероцит
3. Шюфнерийн мөхлөг
4. Гейнцийн биет
5. Делен биет

/286./ Чанарын гарын авлага (ЧГА):

1. ЧГА нь чанарын системийн үндсийг бүрдүүлдэг учраас түүнийг өөрчилж болохгүй
2. ЧГА-д шинжилгээний бүх аргачлал байх ёстой
3. ЧГА-ыг олон хувиар хэвлэж тараана
4. ЧГА нь лабораторит баримтлах чанарын бодлогыг тогтооно
5. ЧГА нь ажилтнуудын ширээний ном мөн

/287./ WBC –ийн Гистограм дээр ямар эсүүд дүрслэгддэг вэ?

1. Лимфоцит
2. Эозинофил, базофил, моноцит (Дунд эс-Middle cell)
3. Нейтрофил
4. Савхан бөөмт нейтрофил
5. тасархай бөөмт нейтрофил

/288./ Маркерийн шинжилгээнд ... нөлөөлж болно

1. Элэг бөөрний үйлийн хямралын үед бодисын солилцоо хямарснаас хуурамч эерэг хариу гарч болно.

2. Мэс ажилбаруудын гэмтлийн нөлөөгөөр хавдрын маркерууд ихэсч болно.

3. Жирэмсэн үед, сарын мөчлөгийн үед хавдрын маркеруудын агууламж өөрчлөгдөж болно.

4. Заавал өлөн үедээ шинжилгээ өгөх ёстой

5. Зөвхөн хавдрын үед огцом ихсэж архаг үрэвслийн үед ихсэхгүй байдаг онцлогтой  
/289./ Дараах хариултын аль нь зөв бэ ?

1. Сорьцын байдлаас хамаарахгүй шинжилгээнд оруулах шаардлагатай

2. Сорьцыг буруу бэхжүүлэгчтэй хуруу шилэнд авсан бол уг сорьцыг шинжилгээнд хэрэглэж болохгүй

3. Хуруу шилэн дээр өвчтөний зөвхөн нэр байвал сорьцыг шинжилгээнд оруулахад хангалттай

4. Хангалтгүй хэмжээтэй сорьцыг шинжилгээнд хэрэглэж болохгүй

5. Өвчтөний талаар ямар ч мэдээлэл байхгүй сорьцыг шинжилж болно

/290./ Цаасан дээр тэмдэглэж мэдээлэл зүйг хөтлөн явуулдаг бол дараах хариултын аль нь зөв бэ?

1. Мэдээллийг архивт хадгалах, хайж олоход хялбар.

2. Чанарын хяналтын хариунд анализ хийхэд хялбар, тооцооллыг автоматаар хийдэг.

3. Өвчтөний тухай дэлгэрэнгүй мэдээлэл бага шаардана.

4. Зөв боловсруулсан маягт, журнал нь ашиглахад хялбар, мэдээллийг бүрэн агуулсан байдаг

5. Үргэлж хуулбар хувь хийх шаардлагатай.

/291./ Чанарын менежерийн үүрэгт дараах ажил орно. Үүнд:

1. Чанарын хяналтын сорьцыг өвчтөний сорьцтой адил шинжилнэ

2. Чанарын системийн бүх асуудалд байнгын ажиглалт хийнэ

3. Чанарын хяналтын ажиллагаа, ажилбарт шаардлагатай нөөцийг бүрдүүлнэ\*

4. Чанарын удирдлагын тогтолцооны сургалт явуулна

5. Лабораторит өндөр чадавхитай чанарын сургагч багш урина

/292./ Цэрэнд Шарко-Лейдиний талст илрэх нь ямар эстэй холбоотой вэ

1. Эритроцит

2. Тромбоцит

3. Моноцит

4. Эозинофил

5. плазмоцит

/293./ Угаасан улаан эс ашиглан цусны АВО бүлгийг тодорхойлох урвалын зарчмыг хэлнэ үү

1. Оношлууртагуулагдажбайгаа эсрэгбиеийг ашиглан улаан эсийн гадаргуу дээр байгаа эсрэгтөрөгчийг тодорхойлох

2. Оношлууртагуулагдажбайгаа эсрэгтөрөгчийг ашиглан ийлдсэнд агуулагдаж байгаа эсрэгбиеийг тодорхойлох

3. Дээрхи хоёр хариултын аль нь ч биш

4. Стандарт А болон В эсрэгтөрөгч ашиглан ийлдсэнд агуулагдах  $\beta$ ,  $\alpha$  эсрэгбие тодорхойлох

5.  $\beta$ ,  $\alpha$  эсрэгбиеашиглан улаан эсийн гадаргуу дээр байгаа эсрэгтөрөгчийг тодорхойлох

/294./ Түүдгэнцрийн цочмог үрэвслийн үеийн шинж:

1. Цилиндрури

2. Протеинури

3. Гематури

4. Оксалатури

5. Бактериури

/295./ Хоол хүнсний хамт гаднаас авсан нүүрсус бие махбодийн дотор боловсорч задраад голдуу глюкоз болдог. Яагаад гэвэл бусад моносахарууд ч глюкозад шилжээд шимэгдэх тул цус болон бүхий л биологийн шингэнүүдэд нүүрсус нь голдуу глюкоз байдлаар оршдог.

/296./ Хавдрын маркерийг тодорхойлох арга нь эсрэгбие антигений харилцан үйлчлэл дээр үндэслэсэн байдаг. Иймд эдгээрийг ийлдсэнд тодорхойлж болно.

/297./ Венийн судсыг хатгаж цус авсны дараа хөвөн бөмбөлгөөр сайн дарах шаардлагатай. Энэ нь цус хуралт үүсэхээс сэргийлнэ.

/298./ Лабораторид чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх нь шинжилгээний үнэн зөв байдлыг баталгаажуулж чанарын ба тооны шинжилгээний аргын ялгааг тогтоосноор шинжилгээнд алдаа гарахаас сэргийлнэ.

/299./ Хавдрын маркерыг зөвхөн *in vivo* орчинд тодорхойлдог учир нь хавдрын маркерийг тодорхойлсноор хавдрыг эрт шатанд нь илрүүлэх боломжтой.

/300./ Эмнэл зүйн сорьцыг шинжилгээнд бэлтгэх ажилбарыг буруу гүйцэтгэсэнээс шалтгаалсан харилцан бохирдолт/*cross contamination*/ нь ПГУ-ын дүн хуурамч эерэг гарах үндсэн шалтгаан болдог/A/

### **Сорилын зөв хариулт**

1-D, 2-A, 3-A, 4-C, 5-A, 6-C, 7-C, 8-D, 9-D, 10-A, 11-B, 12-D, 13-A, 14-B, 15-D, 16-E, 17-E, 18-E, 19-A, 20-A, 21-A, 22-D, 23-A, 24-A, 25-A, 26-A, 27-B, 28-E, 29-C, 30-D, 31-A, 32-B, 33-D, 34-D, 35-A, 36-C, 37-D, 38-B, 39-C, 40-C, 41-C, 42-A, 43-E, 44-D, 45-A, 46-D, 47-C, 48-A, 49-B, 50-D, 51-C, 52-D, 53-B, 54-E, 55-A, 56-A, 57-A, 58-C, 59-C, 60-A, 61-D, 62-A, 63-E, 64-C, 65-A, 66-A, 67-E, 68-E, 69-A, 70-D, 71-C, 72-D, 73-E, 74-A, 75-E, 76-D, 77-C, 78-B, 79-D, 80-A, 81-E, 82-D, 83-C, 84-C, 85-C, 86-B, 87-D, 88-B, 89-D, 90-E, 91-A, 92-B, 93-A, 94-C, 95-C, 96-D, 97-E, 98-B, 99-A, 100-B, 101-C, 102-E, 103-A, 104-E, 105-A, 106-E, 107-D, 108-C, 109-D, 110-D, 111-C, 112-D, 113-B, 114-E, 115-E, 116-B, 117-C, 118-B, 119-A, 120-D, 121-C, 122-E, 123-A, 124-B, 125-C, 126-C, 127-B, 128-B, 129-E, 130-C, 131-E, 132-E, 133-B, 134-D, 135-D, 136-A, 137-B, 138-D, 139-D, 140-A, 141-D, 142-B, 143-B, 144-A, 145-C, 146-C, 147-D, 148-B, 149-D, 150-B, 151-B, 152-E, 153-B, 154-B, 155-B, 156-C, 157-B, 158-B, 159-D, 160-A, 161-D, 162-A, 163-D, 164-A, 165-B, 166-E, 167-C, 168-D, 169-D, 170-A, 171-C, 172-E, 173-B, 174-E, 175-C, 176-A, 177-D, 178-A, 179-B, 180-B, 181-E, 182-B, 183-E, 184-C, 185-A, 186-A, 187-D, 188-E, 189-B, 190-A, 191-E, 192-D, 193-D, 194-A, 195-B, 196-A, 197-B, 198-C, 199-D, 200-D, 201-B, 202-A, 203-A, 204-E, 205-B, 206-C, 207-C, 208-B, 209-D, 210-A, 211-C, 212-A, 213-B, 214-D, 215-B, 216-D, 217-B, 218-A, 219-C, 220-C, 221-E, 222-B, 223-C, 224-A, 225-E, 226-C, 227-C, 228-A, 229-C, 230-B, 231-A, 232-E, 233-C, 234-D, 235-B, 236-C, 237-A, 238-E, 239-E, 240-C, 241-A, 242-A, 243-E, 244-C, 245-E, 246-A, 247-E, 248-C, 249-A, 250-B, 251-C, 252-A, 253-B, 254-E, 255-B, 256-D, 257-B, 258-D, 259-B, 260-C, 261-B, 262-A, 263-D, 264-C, 265-E, 266-A, 267-E, 268-A, 269-C, 270-C, 271-A, 272-B, 273-C, 274-D, 275-B, 276-D, 277-E, 278-C, 279-D, 280-C, 281-A, 282-A, 283-E, 284-A, 285-C, 286-C, 287-A, 288-B, 289-C, 290-D, 291-B, 292-D, 293-C, 294-A, 295-A, 296-A, 297-A, 298-A, 299-C, 300-D,